

Хурлын протокол

2011.05.01

№

Дархан-Уул аймаг

"Силикат" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал компанийн байранд 2011 оны 05 сарын 1-ний өдөр 15 цагт 99,36 % ирцтэйгээр хурал эхлэв. Хуралд 7 хувь нийлүүлэгчид оролцов.

д/д	Хувь нийлүүлэгчдийн нэр	Эзэмших хувьцааны тоо	Эзэмших хувь хэмжээ	Бусад
1	Ц.Содбилэг	42 438	24.94	
2	Ц.Сэргэлэн	2 552	1.5	
3	Н.Цогцлон	12 760	7.5	
4	С.Золбоотөгс	36 947	21.72	
5	С.Оджаргал	32 199	18.93	Итгэмжлэлээр
6	В.Мөнхтуяа	20 415	12.00	
7	Д.Энхболд	21 726	12.77	
	Нийт	169 037	99.36	

Хурлаар хэлэлцэх асуудал

- ✓ Нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой асуудлууд дээр ярилцаж, шийдвэр гаргах
- ✓ Бусад

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Ж.Ганболд хурлыг нээв: Та бүхэнд хуралд хүрэлцэн ирсэнд талархаж байгаагаа илэрхийлээд, хурал нээснийг мэдэгдэе. Энэ хурлаар бид нэмэлт хувьцаа гаргахдаа хувьцааг хэрхэн хуваах, нэрлэсэн үнийг хэдээр, зах зээлд санал болгох доод үнийг хэдээр тогтоох вэ гэдэг асуудлуудыг танилцуулж шийдвэр гаргахаар цуглаад байна.

Ц.Содбилэг: Нэгж хувьцааг 177 ширхэгт хуваахаар төлөвлөсөн байгаа. Хувьцаа хуваагдсаны дараа нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 30 112 302 ширхэг энгийн хувьцаатай байх юм. Компанийн 35%-тай тэнцэх 16 222 300 ширхэг хувьцааг зах зээлд зах зээлд 225 төгрөгөөр санал болгон хөчөнгө татан төвлөрүүлж, төвлөрсөн хөрөнгөөрөө өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэж, шохой үйлдвэрлэлийн хүчин чадал, ашигт ажиллагааг нэмэгдүүлж ажиллана. Энэ тал дээр та бүхнийг дэмжиж ажиллах байх гэдэгт найдаж байна.

Ц.Сэргэлэн: Шаардлагатай байгаа 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг татахад ийм хувилбар нь илүү дөхөмтэй байгаа гэж үзэж байгаа бол би дэмжиж байна.

Н.Цогцлон: Дэмжиж байна.

Д.Энхболд: Санал нэгтэй байна.

В.Мөнхтуяа: Саналыг зөвшөөрч байна

Ж.Ганболд: Өнөөдрийн хуралд идэвхитэй оролцож, санал нэгтэй байгаад та бүхэнд талархаж байна.

Хурлаас:

1. Компани нь өөрийн хувьцааны зах зээл дэх эргэлтийг идэвхижүүлэх, нэмэлт хувьцаа гаргах зорилгоор нэгж хувьцааг 177 ширхэгт хуваах. Хувьцаа хуваагдсаны дараа компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 30 112 302 (гучин сая нэг зуун арван хоёр гурван зуун хоёр) ширхэг энгийн хувьцаатай байх.
 2. Компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор компанийн 35%-тай тэнцэх 16 222 300 (арван зургаан сая хоёр зуун хорин хоёр гурван зуу) ширхэг хувьцааг зах зээлд санал болгон хөрөнгө татан төвлөрүүлэх
 3. Нэмж гаргаж буй хувьцааг зах зээлд санал болгох доод үнийг 225 төгрөгөөр тогтоох.
 4. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан шинэчилсэн найруулга бүхий дүрмийг батлах
- зэрэг асуудлууд дээр санал хурааж, хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар дэмжиж баталлаа. Асуудлуудыг бүрэн хэлэлцэж дууссан тул хурлыг 17 цагт өндөрлөв.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

Ц.Содбилэг

Ц.Сэргэлэн

Н.Цогцлон

В.Мөнхтуяа

Ц.Золбоотөгс

Д.Энхболд

Ц. Содбилэг
Ц. Сэргэлэн
Н. Цогцлон
В. Мөнхтуяа
Ц. Золбоотөгс
Д. Энхболд

Хурлын протокол хөтөлсөн

Ш. Батмөнх

Ш.Батмөнх